

Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс

ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Алтай хот
2018 он

Агуулга



**АЙМГИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**..... 2



ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ3

АХУЙН НӨХЦӨЛ4



**СУРАЛЦАХ
НӨХЦӨЛ**5



**ЭРҮҮЛ АМЬДРАХ
ОРЧИН**6



**АЮУЛГҮЙ
БАЙДАЛ** 7-8



ХҮҮХЭД ГЭР БҮЛ9



АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Говь-Алтай аймаг нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 18 сум, 2 тосгон 87 баг, 58,4 мянган хүн ам, 16,7 мянган өрхтэй. Нийт өрхийн 30.6 хувь нь аймгийн төвд, 19.8 хувь нь сумын төвд, 46.8 хувь нь хөдөөд, 2.8 хувь нь тосгонд суурьшсан.

Өдгөө зах зээлийн нөхцөлд хөдөө аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, барилга, барилгын материал, аялал жуулчлалын салбаруудыг хөгжүүлж, орон нутгийн хөгжил дэвшилд хувийн хэвшлийн оролцоо дийлэнх хувийг эзэлж, бүтээн байгуулалт, бизнесийн цар хүрээ өдрөөс өдөрт өргөжин тэлж байна. Хосгүй сайхан байгаль өнө мөнх дурсагдах уламжлалт ёс заншлаа сэргээн хайрлан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, айл хотол, ахан дүүсээрээ ажлын байр бий болгож, амьдрал ахуйгаа дэвжээж, их бүтээн байгуулалтын ажилд Алтайчууд шамдан ажиллаж байна.

Говь-Алтай аймаг Монгол улсын баруун зүгт зүүн талаараа Баянхонгор, хойд талаараа Завхан, баруун талаараа Ховд, өмнөд талаараа БНХАУ-тай хил залган оршино. Аймгийн БНХАУ-тай хиллэдэг хилийн урт 360 км болж тэдгээр нь хилийн 128-171 дүгээр тэмдгээр тэмдэглэгджээ.

Говь-Алтай аймгийн нийт нутаг дэвсгэр 141.4 мянган хавтгай дөрвөлжин бөгөөд. Улаанбаатар хотоос 1001 км зайд оршдог Дэлхийн цагийн 6 дугаар бүсэд байрладаг уул, тал, хөндий, уужим, тавиун хотгор, хонхор хосолсон газрын гадаргуутай.



ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Аймгийн нийт өрх 16711 болж, өнгөрсөн оноос 1.3 хувь буюу 210 өрхөөр нэмэгдсэн байна. Нийт өрхийн 24.6 хувь нь аймгийн төвд, 30.8 хувь нь сумын төвд, 44.6 хувь нь хөдөөд суурьшсан байна.

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдэж 2010 оноос орон сууцанд амьдардаг өрхийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч нийт өрхий 72.7 хувь нь гэр хороололд оршин сууж байна./2019 оны 07 сарын байдлаар/

Байршил	Үүнээс					
	Бие даасан тохилог сууц	Бусад сууц	Гэр	Нийтийн байр	Орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин
ГОВЬ-АЛТАЙ	86	88	13 621	221	1256	1421

/2019 оны 07 сарын байдлаар/

Нийт өрхийн 79.9 хувь нь гэр хороололд, 15.0 хувь нь сууцны тусдаа байшинд, 3.8 хувь нь орон сууцны байшинд, 0.4 хувь нь нийтийн зориулалттай бусад сууцанд, 0.1 хувь нь бие даасан тохилог сууцанд тус тус амьдарч байна.





АХУЙН НӨХЦӨЛ

ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР		2019.07
Төвлөрсөн систем		7672
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж		7063
Бага оврын цахилгаан үүсгүүр		1329
Дизель станц		360
Цахилгааны эх үүсвэргүй		270
УСАН ХАНГАМЖ		2019.07
Бие даасан систем - халуун, хүйтэн устай		22
Бие даасан систем - хүйтэн		36
Зөөврийн		15144
Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай		151
Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай		1341
ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР		2019.07
Ердийн галлагаа		14790
Нам даралтын зуух		289
Төвлөрсөн систем		1578
Цахилгаан халаагуур		128




СУРАЛЦАХ НӨХЦӨЛ

Ерөнхий боловсролын сургууль 2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн тогтолцоонд шилжиж, 6 настай хүүхдийг нэгдүгээр ангид элсүүлэх болсноор 5 хүртэлх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна.

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 28 сургуулийн 793 бүлэгт 21517 хүүхэд өдрөөр суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн тоо 2017 онд 1145 байгаагийн 34.9 хувь нь бага ангийн, 38.5 хувь нь дунд ангийн, 26.6 хувь нь ахлах ангийн багш байна.

Ерөнхий боловсролын 28 сургууль, 29 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад 11.4 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.5 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1272 хүүхэд элсэн суралцаж байна.






ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧИН

2018 онд 1277 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1286 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эх 61 буюу 5.0 хувиар хүүхэд 65-аар буюу 5.3 хувиар тус тус өссөн байна. Нийт 114 хүн нас барсанаас эмнэлэгт 28 хүн нас барсан байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст 1277 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1286 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эх 61 буюу 5.0 хувиар, хүүхэд 65-аар буюу 5.3 хувиар тус тус өссөн байна.




Нялхасын эндэгдэл 21 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 тохиолдолоор 5.3 хувиар өсч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 4 тохиолдол бүртгэгдсэн байна.


1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 16.3 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.1 пунктээр өссөн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19.4 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.3 пунктээр өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2018 оны эцэст 536 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 249 буюу 31.7 хувиар буурчээ. Халдварт өвчлөл буурахад гар хөл амны өвчин өмнөх оны мөн үеэс 77.8 буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 12 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2018 оны 12 сарын байдлаар





АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Байгууллага, иргэдийн 497.4 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж 203 гэмт хэрэг гарчээ. Эдгээр хэргүүдээс хөнгөн гэмт хэрэг 155 (76.4%), хүнд гэмт хэрэг 48 (23.6%) эзэлж байна.

Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50 (24.6%), хулгайн гэмт хэрэг 49 (24.1%), залилах гэмт хэрэг 45 (22.2%), бусад хэрэг 59 (29.1%), нийт хэргийн 120 (59.1%) нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.




Баривчлагдсан хүний тоо 114, өмнөх оны мөн үеэс 26 (18.6%), хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл 1114, өмнөх оны мөн үеэс 248 (18.2%), гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 329 өмнөх оны мөн үеэс 69 (15.0%) тус тус буурсан байна.

Нийт зөрчил 9456 өмнөх оны мөн үеэс 3310 (44.9%), торгуулсан хүн, хуулийн этгээд 9083 өмнөх оны мөн үеэс 3310 (57.3%), тээврийн хэрэгсэл


жолоодох эрхээ хасуулсан хүний тоо 200 (15%) тус тус өссөн байна.

Гэмт хэргийн хэлбэр тоо 2018



■ Хөнгөн ■ Хүнд

Гэмт хэргийн төрөл хувиар 2018



ХҮҮХЭД ГЭР БҮЛ

Аймгийн хэмжээгээр 2018 онд өнчин хүүхдийн тоо 1049 болж, нийт хүүхдийн 5.1 хувийг эзэлж байна. Нийт өнчин хүүхдийн 5.1 хувь буюу 54 хүүхэд нь бүтэн өнчин, 94.9 хувь буюу 995 нь хагас өнчин хүүхдүүд байна. Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар өрх толгойлсон эмэгтэй 842, өрх толгойлсон эрэгтэй 64 байна.

БҮТЭН ӨНЧИН, ХАГАС ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО

	Бүтэн өнчин хүүхдийн тоо		Хагас өнчин хүүхдийн тоо	
	2017	2018	2017	2018
Бүгд	51	54	969	995

БҮРТГҮҮЛСЭН ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ

	Гэрлэлт		Цуцлалт		Үрчлэлт	
	2017	2018	2017	2018	2017	2018
Бүгд	315	302	25	15	24	22

